

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/37/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Нурлан  
Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага .....	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯННУУР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА Е.ЖАНЫЛ

2023.02.24 № 122  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 138.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

#### Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *(Signature)* М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>102,523,526.55</u></b>	<b><u>170,635,647.63</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	27,422,561.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	27,422,561.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	27,422,561.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	27,422,561.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	26,600,000.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	26,600,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	75,923,526.55	143,213,086.63
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,544,402.00	83,526,571.00
35130	Эм боох материал	14,544,402.00	83,526,571.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	61,379,124.55	59,686,515.63
35410	Бичиг хэргийн материал	1,099,900.00	2,603,100.00
35420	Аж ахуйн материал	27,479,474.00	35,719,405.00
35440	Түлш, шатах тослох материал	130,000.00	130,000.00
35460	Хүнсний материал	3,268,638.71	5,667,811.51
35470	Бусад хангамжийн материал	29,401,111.84	15,566,199.12
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>881,959,851.06</u></b>	<b><u>970,483,729.32</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	881,959,851.06	970,483,729.32
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	876,191,851.06	964,715,729.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	824,562,603.82	824,562,603.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	-64,232,788.86	-77,585,884.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,638,199.00	69,606,056.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-39,292,925.28	-20,260,782.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	95,594,594.16	190,634,365.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,263,997.03	-32,532,316.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,430,128.80	28,958,128.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,343,963.55	-18,766,441.44
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,601,500.00	5,601,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,601,500.00	-5,601,500.00
39217	Ном	100,000.00	100,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5,768,000.00	5,768,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,768,000.00	5,768,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>984,483,377.61</u></b>	<b><u>1,141,119,376.95</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>22,948,467.08</u></b>	<b><u>257,884.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	22,948,467.08	257,884.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	22,948,467.08	257,884.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,939,868.00	135,484.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>18,008,599.08</b>	<b>122,400.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	18,008,599.08	122,400.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>961,534,910.53</b>	<b>1,140,861,492.95</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>961,534,910.53</b>	<b>1,140,861,492.95</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	481,899,043.00	481,899,043.00
51101	Өмч: - төрийн	481,899,043.00	481,899,043.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>37,407,677.82</b>	<b>216,734,260.24</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	37,407,677.82	37,407,677.82
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	179,326,582.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	442,228,189.71	442,228,189.71
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>984,483,377.61</b>	<b>1,141,119,376.95</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>771,537,957.00</b>	<b>898,545,292.12</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>617,840,930.00</b>	<b>138,590,432.12</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	55,340,670.00	138,590,432.12
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	55,340,670.00	138,590,432.12
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,015,615.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	54,325,055.00	138,590,432.12
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	4,683,660.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	4,683,660.00	00.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	557,816,600.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	557,816,600.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>153,697,027.00</b>	<b>759,954,860.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	104,371,627.00	310,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,371,627.00	310,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	49,325,400.00	45,618,500.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,025,400.00	45,618,500.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	21,300,000.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	714,026,360.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	714,026,360.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>694,582,374.82</b>	<b>719,218,709.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>694,582,374.82</b>	<b>719,218,709.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	652,582,374.82	718,450,207.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	412,642,931.32	417,797,995.00
210101	Үндсэн цалин	411,095,563.00	414,797,995.00
210104	Урамшуулал	1,341,679.32	1,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	205,689.00	2,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,508,134.76	52,687,500.00
210201	Тэтгэврийн даатгал	52,508,134.76	52,687,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,209,000.00	41,833,748.00
210301	Гэрэл, цахилгаан	1,837,700.00	2,668,248.00
210302	Түлш, халаалт	25,371,300.00	39,165,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	47,715,127.00	67,593,197.92
210401	Бичиг хэрэг	3,536,550.00	5,020,700.00
210402	Тээвэр, шатахуун	36,012,827.00	53,264,845.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,585,000.00	1,665,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,878,650.00	4,221,752.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	702,100.00	3,420,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	78,983,961.32	101,543,514.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,999,865.00	89,614,911.84
210502	Хоол, хүнс	8,976,181.32	10,300,552.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,007,915.00	1,628,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,511,907.00	12,470,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,723,443.00	3,570,950.00
210604	Урсгал засвар	788,464.00	8,899,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,059,131.00	1,383,500.00
210702	Дотоод албан томилолт	3,059,131.00	1,383,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,187,790.00	1,178,500.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,061,390.00	330,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	160,400.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	279,400.00	98,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	114,200.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	214,500.00
210807	Газрын төлбөр	47,400.00	56,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,764,392.42</b>	<b>21,961,352.74</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	190,500.00	5,917,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,573,892.42	16,043,892.74
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,000,000.00</b>	<b>768,502.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,000,000.00</b>	<b>-</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	42,000,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>768,502.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	768,502.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>76,955,582.18</u></b>	<b><u>179,326,582.42</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>12,755,856.14</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,750,000.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5,856.14	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(12,755,856.14)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>64,199,726.04</u></b>	<b><u>179,326,582.42</u></b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>786,554,899.00</b>	<b>758,363,797.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	786,554,899.00	758,363,797.00
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	786,554,899.00	758,363,797.00
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	427,602,379.00	422,602,379.00
Үндсэн цалин	299,803,479.00	294,803,479.00
Нэмэгдэл	83,245,200.00	83,245,200.00
Унаа хоолны хөнгөлөлт	7,470,000.00	7,470,000.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Урамшуулал	30,112,300.00	30,112,300.00
Гэрээт ажлын хөлс	6,971,400.00	6,971,400.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>53,312,500.00</b>	<b>52,687,500.00</b>
Тэтгэврийн даатгал	36,252,500.00	35,827,500.00
Тэтгэмжийн даатгал	4,265,000.00	4,215,000.00
ҮОМШӨ-ний даатгал	3,412,000.00	3,372,000.00
Ажилгүйдлийн даатгал	853,000.00	843,000.00
Эрүүл мэндийн даатгал	8,530,000.00	8,430,000.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>42,302,500.00</b>	<b>41,833,748.00</b>
Гэрэл, цахилгаан	3,137,000.00	2,668,248.00
Түлш, халаалт	39,165,500.00	39,165,500.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>66,953,000.00</b>	<b>64,063,000.00</b>
Бичиг хэрэг	4,309,600.00	3,419,600.00
Тээвэр, шатахуун	55,280,000.00	53,280,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,010,000.00	3,010,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариугал	2,512,600.00	2,512,600.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,840,800.00	1,840,800.00
<b>Нормативт зардал</b>	<b>132,356,700.00</b>	<b>126,556,700.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	116,281,625.00	111,281,625.00
Хоол, хүнс	13,815,275.00	13,015,275.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,259,800.00	2,259,800.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>29,588,300.00</b>	<b>17,060,950.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	26,068,100.00	13,840,500.00
Урсгал засвар	3,520,200.00	3,220,450.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,263,500.00</b>	<b>1,383,500.00</b>
Дотоод албан томилолт	2,263,500.00	1,383,500.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,428,500.00</b>	<b>1,428,500.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	530,000.00	530,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	98,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,500.00	264,500.00
Газрын төлбөр	56,000.00	56,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,747,520.00</b>	<b>30,747,520.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	30,747,520.00	30,747,520.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>786,244,860.00</b>	<b>785,476,358.00</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>45,618,500.00</b>	<b>44,849,998.00</b>
Орон нутгийн төсвөөс	45,618,500.00	44,849,998.00
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>740,626,360.00</b>	<b>740,626,360.00</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	740,626,360.00	740,626,360.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		27,422,561.00
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	30.00	34.00
Удирдах ажилтан	1.00	1.00
Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
Үйлчлэх ажилтан	8.00	11.00
Гэрээт ажилтан	0.00	1.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	37,407,677.82	961,534,910.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>481,899,043.00</b>	<b>442,228,189.71</b>	<b>37,407,677.82</b>	961,534,910.53
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>481,899,043.00</b>	<b>442,228,189.71</b>	<b>37,407,677.82</b>	961,534,910.53
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>481,899,043.00</b>	<b>442,228,189.71</b>	<b>37,407,677.82</b>	961,534,910.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>481,899,043.00</b>	<b>442,228,189.71</b>	<b>37,407,677.82</b>	961,534,910.53
D08	Тайлант үеийн үр дүн			179,326,582.42	179,326,582.42
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>481,899,043.00</b>	<b>442,228,189.71</b>	<b>216,734,260.24</b>	1,140,861,492.95

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>786,554,899.00</b>	<b>758,363,797.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	786,554,899.00	758,363,797.00
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	786,554,899.00	758,363,797.00
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	427,602,379.00	422,602,379.00
Үндсэн цалин	299,803,479.00	294,803,479.00
Нэмэгдэл	83,245,200.00	83,245,200.00
Унаа хоолны хөнгөлөлт	7,470,000.00	7,470,000.00
Урамшуулал	30,112,300.00	30,112,300.00
Гэрээт ажлын хөлс	6,971,400.00	6,971,400.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>53,312,500.00</b>	<b>52,687,500.00</b>

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тэтгэврийн даатгал	36,252,500.00	35,827,500.00
Тэтгэмжийн даатгал	4,265,000.00	4,215,000.00
ҮОМШӨ-ний даатгал	3,412,000.00	3,372,000.00
Ажилгүйдлийн даатгал	853,000.00	843,000.00
Эрүүл мэндийн даатгал	8,530,000.00	8,430,000.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>42,302,500.00</b>	<b>41,833,748.00</b>
Гэрэл, цахилгаан	3,137,000.00	2,668,248.00
Түлш, халаалт	39,165,500.00	39,165,500.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>66,953,000.00</b>	<b>64,063,000.00</b>
Бичиг хэрэг	4,309,600.00	3,419,600.00
Тээвэр, шатахуун	55,280,000.00	53,280,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,010,000.00	3,010,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,512,600.00	2,512,600.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,840,800.00	1,840,800.00
<b>Нормативт зардал</b>	<b>132,356,700.00</b>	<b>126,556,700.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	116,281,625.00	111,281,625.00
Хоол, хүнс	13,815,275.00	13,015,275.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,259,800.00	2,259,800.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>29,588,300.00</b>	<b>17,060,950.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	26,068,100.00	13,840,500.00
Урсгал засвар	3,520,200.00	3,220,450.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,263,500.00</b>	<b>1,383,500.00</b>
Дотоод албан томилолт	2,263,500.00	1,383,500.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,428,500.00</b>	<b>1,428,500.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	530,000.00	530,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	98,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,500.00	264,500.00
Газрын төлбөр	56,000.00	56,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,747,520.00</b>	<b>30,747,520.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	30,747,520.00	30,747,520.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>786,244,860.00</b>	<b>785,476,358.00</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>45,618,500.00</b>	<b>44,849,998.00</b>
Орон нутгийн төсвөөс	45,618,500.00	44,849,998.00
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>740,626,360.00</b>	<b>740,626,360.00</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	740,626,360.00	740,626,360.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>27,422,561.00</b>
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>30.00</b>	<b>34.00</b>
Удирдах ажилтан	1.00	1.00
Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
Үйлчлэх ажилтан	8.00	11.00

Гэрээт ажилтан	0.00	1.00
----------------	------	------

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>310000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>310000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	310000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	310000.00
210702	Дотоод албан томилолт		310000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	310000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	310000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		310000.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн чиг үүрэг, зорилго нь үйлчлэх хүрээний хүн амьд эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг жигд, чирэгдэлгүй, чанартай, хүртээмжтэй үзүүлэх чиг үүрэг бүхий зорилготой байгууллага юм.

Төрөөс эрүүл мэндийн талаарх баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөр, стратеги бүрийн хүрээнд өөрийн байгууллагад хамаарах зорилго, зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагаанд тусгаж ажилласан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөг 8 бүлгээр батлан хэрэгжүүл, төлөвлөгөөний биелэлт 89 хувиар гарсан бол 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 91 хувиар үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Баяннуур сумын Эрүүл мэндийн нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайланд хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тайлант оноос үйл ажиллагааны хувьсах зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоонд шилжиж, санхүүгийн тайлангаа Эрүүл мэндийн яаманд нэгтгэлд тушаадаг болсон байна.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн тушаалаар баталсан НББ-ийн бүртгэлийн бодлогын баримт бичгийг ажилдаа мөрдлөг болгосон байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын Эрүүл мэнд нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 156.6 сая төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		27,422.6	27,422.6
Авлага	26,600.0		-26,600.0
Бараа материал	75,923.5	143,213.1	67,289.6
Үндсэн хөрөнгө	881,959.8	970,483.7	88,523.9

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>Нийт хөрөнгө</b>	<b>984,483.4</b>	<b>1,141,119.4</b>	<b>156,636.0</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	984,483.4	1,141,119.4	156,636.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>984,483.4</b>	<b>1,141,119.4</b>	<b>156,636.0</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө 27.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Бараа материалын данс 67.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 232.8 сая төгрөгийн материал худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас үнэгүй 54.0 сая төгрөгийн эм боох материал, бусад хангамжийн материал авч, үйл ажиллагаанд 205.2 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж, 14.2 сая төгрөгийн хөрөнгийн акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 88.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 19.9 сая төгрөгийн хөрөнгийн худалдан авч, 84.6 сая төгрөгийн хандиваар, 19.0 сая төгрөгийн авто тээврийн хэрэгслийг шилжүүлж, үндсэн хөрөнгөд 16.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 156.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь гүйцэтгэлээрээ санхүүждэг ба 2022 онд төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 740.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 45.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогоос 0.3 сая төгрөг нийтдээ 786.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийгмийн даатгалын сангаас 740.0 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 45.6 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчаас 0.3 сая төгрөгийг нийтдээ 786.5 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж гүйцэтгэлээр 758.3 сая төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаанд зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 758.3 сая төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 27.4 сая төгрөгөөр дутуу зарцуулж жилийн эцэст орон нутгийн төсвөөс дутуу зарцуулсан 0.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>Хөтөлбөр -71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>	<b>740,936.3</b>	<b>713,513.8</b>	<b>27,422.5</b>	<b>96,5%</b>
1.1	Арга хэмжээ-80302 Нэг иргэнд ногдох нормативаар	375,047.4	375,047.4	0	0%

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.2	Арга хэмжээ-81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	336,168.9	308,746.40	27,422.5	96,5%
1.3	Арга хэмжээ-83603 Дээд шатны төсвөөс хуваарилсан	29,720.0	29,720.0	0	0%
<b>2</b>	<b>Хөтөлбөр-71601. Нийгмийн эрүүл мэнд</b>	<b>45,618.5</b>	<b>44,849.9</b>	<b>768.6</b>	<b>1.7%</b>
2.1	Арга хэмжээ-80112 Нийтлэг үйлчилгээ	45,618.5	44,849.9	768.6	1.7%
	<b>Дүн</b>	<b>786,554.80</b>	<b>758,363.7</b>	<b>28,191.1</b>	<b>96,5%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн нь 2022 онд 310.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 694.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил 5.0 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0.6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 2.8 сая төгрөг, нормативт зардал 5.8 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 12.5 сая төгрөг, томилолт, зочны зардал 0.9 сая төгрөгийг тус тус хэмнэлттэй зарцуулж, орон нутгийн төсвийн хөрөнгийг 0.7 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 58.8 сая төгрөгийн 9 удаагийн мөнгөн гүйлгээ, төсөв өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 3.6 сая төгрөгийн 1 шийдвэрийг тус тус мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 50 хувьтай байна

Шийдвэрлэсэн нь: Аудитын дүнгээр шилэн дансны зөрлийг арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 87.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	87,300.0		0	0%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>87,300.0</b>		<b>0</b>	<b>0%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 278.6 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 114.7 сая төгрөгийн албан шаардлага, 163.9 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө. Хууль хяналтын байгууллагад албан шаардлагаар шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн асуудал байхгүй.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

#### 5.2 Албан шаардлага

1. Дотод албан томилолтын зардал, тээврийн хөлсний зардал, цахилгааны төлбөр, шүүхийн шийдвэрт төлсөн төлбөр, программ, сургалтын төлбөрийн зардлуудын нийт 21.4 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 30,839.3 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 9 удаагийн 58,792.1 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ, төсөв өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 3,630.5 мянган төгрөгийн 1 шийдвэрийг тус тус мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 1. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

### 1.1. Илрүүлэлт:

1. Бараа үйлчилгээний бусад зардал 14.1 сая төгрөг, норматив зардал 60.0 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 34.4 сая төгрөг, эд хогшил, урсгал, засварын зардал 10.3 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 35.1 сая төгрөг нийтдээ 154.1 сая төгрөгийн зардлыг нягтлан бодох бүртгэлийн бүрдэл дутуу баримтаар, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын НХМаягт ТМ-5 төлбөрийн баримт авалгүйгээр зарцуулсан байна.

### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарлагын гүйлгээ хийхдээ Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан маягтыг мөрдөж, төлбөрийн баримтыг бүрдүүлж ажиллах.

## 2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

### 2.1. Илрүүлэлт:

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Мармара Өлгий ХХК-аас 2.7 сая төгрөгийн, Бек импекс ХХК-аас 1.6 сая төгрөгийн, иргэн А.Бахытжанаас 1.3 сая төгрөгийн, Лекер хоршооноос 2.9 сая төгрөгийн, иргэн Х.Рауаас 0.4 сая төгрөгийн, Ахтолхын ХХК-аас 0.9 сая төгрөгийн нийтдээ 9.8 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийг шууд гэрээгээр худалдан авч төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй байна.

### 2.1 Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”, 14.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн Төсвийн Гүйцэтгэлийн тайлангийн зарим зардлуудад												
<b>Дүн</b>												

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	2	175,523.2			1	21,423.2	1	154,100.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>175,523.2</b>			<b>1</b>	<b>21,423.2</b>	<b>1</b>	<b>154,100.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 30,839.3 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 9 удаагийн 58,792.1 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ, төсөв өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 3,630.5 мянган төгрөгийн 1 шийдвэрийг тус тус мэдээлээгүй	1	93,261.9			1	93,261.9		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>93,261.9</b>			<b>1</b>	<b>93,261.9</b>		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шууд гэрээгээр худалдан авч төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй	1	9,818.0					1	9,818.0
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>103,079.9</b>			<b>1</b>	<b>93,261.9</b>	<b>1</b>	<b>9,818.0</b>